ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН /2016-2021 ОН/

**АУДИТЫН КОД: АГГ-2022/20-ШТА-ГА**

Улиастай сум 2022 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Б.Дагвасүрэн
Утас: 7046-3783, Цахим хаяг dagvasurenb@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Оюунжаргал
Утас: 99460422, Цахим хаяг: oyunjargald@audit.gov.mn
Аудитор Д.Пүүжмаа
Утас: 99080797, Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас www.audit.mn

## АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар..........................................................................................
Аудитын зорилт, хамарсан хүрээ, шалгуур үзүүлэлт, стандарт, арга зүйн талаарх мэдээлэл..........................................................................................................
.

**БҮЛЭГ 1. ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ МӨН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БҮТЭЦ, ЧИГ ҮҮРГИЙН УЯЛДАА ХОЛБОО ХАНГАГДСАН ЭСЭХ**

**1** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан байдал
1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан байдал

1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөсөн байдал

1.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаа

**БҮЛЭГ 2. ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖИЛГҮЙДЛИЙГ БУУРУУЛАХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮР АШИГТАЙ ЭСЭХ**

**Б.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр гадаад болон дотоод зээл, тусламж, бүх төрлийн сан, олон улсын байгууллагуудын санхүүжилттэй төсөл хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн**

Б.2.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа үр нөлөө

Б.2.2 Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөө

Б.2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан /ХЭДС/-ийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлж, үр дүнтэй зарцуулсан байдал

Б.2.4 Мэргэжлийн боловсролын сургалтыг дэмжих сан /МБСДС/ болон Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэн эсэх

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

Б.4.5 "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **ХЭДС** | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан |
| **МБСДС** | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| **МУЕА** | Монгол улсын ерөнхий аудитор |
| **МСҮТ** | Мэргэжил үйлдвэрлэлийн сургалтын төв |
| **СХС** | Сум хөгжүүлэх сан |
| **ЖДҮ** | Жижиг дунд үйлдвэрлэл |
| **ЭМД** | Эрүүл мэндийн даатгал |
| **АДБОУС** | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| **ХХҮГ** | Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар |
| **ЗДТГ** | Засаг даргын Тамгын газар |
| **ҮЭХ** | Үйлдвэрчний эвлэлийн хороо |
| **ОНХС** | Орон нутгийг хөгжүүлэх сан |
| **ААН** | Аж ахуйн нэгж |
| **ГА** | Гүйцэтгэлийн аудит |
| **НББ** | Нягтлан бодох бүртгэл |

## Хавсралтын товьёог

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| *Хавсралт 1* | | |
| *Хавсралт 2* | | |

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй**

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

**Аудитын зорилт**

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт үр дүнд аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн.

Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- *Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх*
- *Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн.хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байна уу*

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитад аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэл, Нийгмийн бодлогын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, ХЭДС, Политехникийн коллеж, МСҮТ-үүд, СХСан, ЖДҮ-ийг хөгжүүлэх сан, Дэлхийн банкны санхүүжилтэй бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг зээл, ЭМД-ын сан холбогдох тайлан мэдээлэл болон холбогдох бусад байгууллагуудын 2016-2021 оны аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулла

**Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Төрийн аудит, Тулгуур зарчим MNS 6817-1:2020 стандарт, Гүйцэтгэлийн аудитын зарчим MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудит аудит хийх журам, гүйцэтгэлийн аудитын журам MNS 6817-7:2020, зэргийг ашиглан, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, санхүүгийн болон ажлын тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр,горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт,зөвлөмж боловсруулла.

**Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа**

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хянан удирдаж, аудитын менежер Б.Дагвасүрэн аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Оюунжаргал, аудитор Д. Пүүжмаа нар 2022 оны 03 сарын 05-ны өдрөөс 2022 оны 05 сарын 05-ны өдрийн хооронд

| | |
|---|---|
| **Ерөнхий мэдээлэл** | гүйцэтгэлээ.<br><br>Аймгийн ХХҮГ-аас ХЭДС-ын хүрээнд 2016-2021 онуудад нийт 2,934.5 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжихэд, аймгийн ЖДҮ-ийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр 2019 онд 5 компанид, 2020 онд 6 компани, 1 хоршоонд нийт 1,477.2 сая төгрөгийн зээлийг олгожээ. |

.

**БҮЛЭГ 1. ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ГАРСАН ДЭЭД ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУСГАЙЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ БАЙХГҮЙ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ЧИГЛЭЛИЙГ ӨГЧ АЖИЛЛААГҮЙН УЛМААС ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГААГҮЙ БАЙНА.**

**1. Дунд хугацаанд баримтлах бодлогын баримт бичиг нь Засгийн газрын урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдаатай байна.**

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

## 1.1 Орон нутагт “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөгүй байна.

Засгийн газрын 2016 оны 320 тоот тогтоолоор “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшнийг бууруулах зорилгоор батлан гаргасан байна. Уг бодлогыг 2016-2026 онуудад дараах 2 үе шатаар хэрэгжүүлэхээр тусгажээ.

- ✓ Нэгдүгээр үе шат 2016-2020 он
- ✓ Хоёр дугаар үе шат 2021-2025 он

Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн үндсэн чиг үүрэг бүхий байгууллагууд дээд байгууллагаас ирүүлсэн чиглэлийн хүрээнд өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн ба хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлд тусгайлсан төлөвлөгөөгүй байна.

## 1.2 2019 онд хийгдсэн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа үндэслэлтэй хийгдсэн байна.

Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа зөвхөн 2019 онд “Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн дунд хугацааны стратеги”-ийг боловсруулах хийгдсэн байна. Судалгаанд 265 аж, ахуйн нэгж, 226 хувиараа хөдөлмөр эрхлэгчид 287 малчин хамрагдсан байна.
Судалгаагаар 49 төрлийн мэргэжлийн хувьд 122 ажлын байр сул байгаагаас 24 мэргэжлийн ажлын байранд мэргэжлийн бус, өөр мэргэжлийн хүн ажиллаж байна.

Мөн нарийн мэргэжил эзэмшсэн иргэдийн тоо цөөн, цалин бага гэсэн шалтгаанаар сул ажлын байранд ажиллах сонирхол багатай, ажлын ачаалал даах чадваргүй, мэргэжлийн ур чадвар, ажлын хариуцлага муу гэсэн дүгнэлт хийгдсэн байна.

## 1.3 Бодлогын баримт бичгийг боловсруулахад бүх талын оролцоог хангасан байна.

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн дунд хугацааны стратеги /2020-2024 оны/ -ийг 2019 он Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, Европын холбооны Монгол Улсад ажлын байр нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх /SECIM/ төсөлтэй хамтран боловсруулан гаргасан гэх боловч баталгаат бодлогын баримт бичиг аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс, ХХҮГазар, эрх бүхий албан тушаалтнуудад байхгүй байна.

Иймд ажлын хэсэгт орж ажилласан зөвлөхөөс бодлогын баримт бичгийн төсөл, зөвлөхийн хураангуй тайланг авч танилцлаа.

Төслийг боловсруулахдаа аймгийн ЗДТГ, ХХҮГ, аймгийн ҮЭХ, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл, Политехникийн коллеж, Статистикийн хэлтсийг оролцуулан Завхан аймгийн хөдөлмөрийн эрэлт, ажлын сул байрыг тодорхойлох үүднээс 24 сумын 115 багт үйл ажиллагаа явуулдаг ААН, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон малчин өрхийн хамруулан түүвэр зах зээлийн судалгаа авч боловсруулсан байна.

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

Судалгаанд 265 аж, ахуйн нэгж, 226 хувиараа хөдөлмөр эрхлэгчид 287 малчин хамрагдсан дүнтэй байна.

Бодлогын баримт бичгийн талаар зөвлөхтэй санал солилцоход “Аймгийн дунд хугацааны ХЭ-ийн стратеги нь Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн, цаашид хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд гол барих бодлогын баримт бичиг болсон, батлан гарсан баримт бичгийг холбогдох албан тушаалтан болон ХХҮГ-т ирүүлээгүй дутагдал байгаа анхаарч ажиллах болно гэсэн тайлбар өглөө.

**2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөн, явуулсан ч төсвийн төслийн саналаар төлөвлөгөөг баталдаггүй байна.**

**2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг өмнөх жилүүдийн батлагдсан төсөв, сумуудын хэрэгцээнд үндэслэн тооцсон байна.**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай төсвийг боловсруулахдаа сумдаас төсөл хөтөлбөрүүдийн хэрэгцээний санал авч, төсвийн төслийг ХХҮЕГ-т хүргүүлэн батлуулдаг байна.

Хүснэгт № *Төсвийн төсөлд хүргүүлсэн санал*

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

| Хөтөлбөрүүд | | Ажлын байрыг дэмжих хөтөлбөр | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр | Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр | Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр | Нийтийг хамарсан ажил зохион байгуулах | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2016** | Төсвийн төсөл | | | | | | | | | 0 |
| | Хамрагдуулах хүн | | | | | | | | | 0 |
| | Батлагдсан төсөв | | 83.5 | 321.7 | 92.3 | | 103.4 | 204.3 | 110.8 | 916 |
| | Хамруулах хүн | | 34 | 78 | 198 | | 169 | 340 | 120 | 939 |
| **2017** | Төсвийн төсөл | | 834.9 | 321.7 | 112.3 | | 103.4 | 284.3 | | 1656.6 |
| | Хамрагдуулах хүн | | 66 | 78 | 218 | | 164 | 460 | | 986 |
| | Батлагдсан төсөв | 460.1 | 71.5 | 297.6 | 92.9 | 34.1 | 42.2 | | | 998.4 |
| | Хамруулах хүн | 518 | 125 | 140 | 169 | 83 | 144 | | | 1179 |
| **2018** | Төсвийн төсөл | 724.4 | 150.4 | 501.5 | 287.4 | 79.6 | 32.5 | | | 1775.8 |
| | Хамрагдуулах хүн | 166 | 159 | 200 | 265 | 90 | 160 | | | 1040 |
| | Батлагдсан төсөв | 363.1 | 112.6 | 315 | 85.3 | 31.2 | 37.4 | | | 944.6 |
| | Хамруулах хүн | 896 | 120 | 182 | 141 | 34 | 202 | | | 1575 |
| **2019** | Төсвийн төсөл | 562.4 | 123.4 | 351 | 177.8 | 52.4 | 132 | | | 1399 |
| | Хамрагдуулах хүн | 946 | 152 | 140 | 201 | 90 | 590 | | | 2119 |
| | Батлагдсан төсөв | 516.4 | 231.2 | 329.7 | 76.4 | 41.3 | 20.6 | | | 1215.6 |
| | Хамруулах хүн | 650 | 120 | 280 | 132 | 26 | 150 | | | 1358 |
| **2020** | Төсвийн төсөл | 558.7 | 331.2 | 415 | 189 | 59.3 | 67.7 | | | 1620.9 |
| | Хамрагдуулах хүн | 875 | 130 | 310 | 184 | 32 | 334 | | | 1865 |
| | Батлагдсан төсөв | 527.3 | 120.7 | 221.1 | 82.8 | 41.8 | 15.6 | | | 1009.3 |
| | Хамруулах хүн | 562 | 112 | 109 | 45 | 22 | 157 | | | 1007 |
| **2021** | Төсвийн төсөл | 616.8 | 236.2 | 329 | 101.4 | 50 | 23.8 | | | 1357.2 |
| | Хамрагдуулах хүн | 1200 | 340 | 150 | 400 | 200 | 170 | | | 2460 |
| | Батлагдсан төсөв | 400.9 | 40.6 | 235.7 | 122.8 | 49.3 | 21.6 | | | 870.9 |
| | Хамруулах хүн | 513 | 1463 | 108 | 76 | 24 | 205 | | | 2389 |
| **Нийт** | **Төсвийн төсөл** | **2462** | **1676.1** | **1918.2** | **867.9** | **241.3** | **359.4** | **284.3** | **0** | **7809.5** |
| | **Хамрагдуулах хүн** | **3187** | **847** | **878** | **1268** | **412** | **1418** | **460** | **0** | **8470** |
| | **Батлагдсан төсөв** | **2268** | **660.1** | **1720.8** | **552.5** | **197.7** | **240.8** | **204.3** | **110.8** | **5954.8** |
| | **Хамруулах хүн** | **3139** | **1974** | **897** | **761** | **189** | **1027** | **340** | **120** | **8447** |

ХХҮГ нь 2016 онд төсвийн төсөл хүргүүлээгүй, 2017-2021 онуудад 7.809,5 сая төгрөгийг 8 хөтөлбөр арга хэмжээнд, 8470 иргэнийг хамруулах төсвийн төслийг хүргүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг бодитой тооцож ХХҮЕГ-таа явуулдаг ч, дээд газар нь төсвийг баталж, хуваарилахдаа 1.854,7 сая төгрөг буюу 23.7 хувиар бууруулан баталсан байгаа нь орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хангалттай баталж өгөөгүй байна.

## 2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн төсвийн төслийг ХХҮЕГ-таа хүргүүлсэн байна.

ХЭДС-ийн орлогын эх үүсвэр нь улсын төсвийн хөрөнгө, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүйн төлбөр, жижиг зээлийн эргэн төлөлт болон бусад эх үүсвэрээс бүрддэг байна.

*Хүснэгт №2 Аймгийн ХЭДС-ын 2016-2021 оны орлогын эх үүсвэрийн судалгаа*

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

| | ХЭДС-ийн орлого | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Улсын төсвийн хөрөнгө | 893.0 | 951.8 | 953.5 | 974.0 | 703.0 | 915.8 |
| 2 | ХБИ-ийг ажиллуулаагүйн төлбөр | 5.4 | 6.2 | 0.4 | 33.4 | 103.0 | |
| 3 | Зээлийн эргэн төлөлт | 60.3 | 76.70 | 129.5 | 313.2 | 303.6 | 347.4 |
| 4 | Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж | | | | | 73.7 | 103.9 |
| 5 | Бусад эх үүсвэр | | 1.1 | | 196.0 | | |
| | | 958.7 | 1,035.8 | 1,083.4 | 1,516.6 | 1,183.3 | 1,367.1 |

2016-2021 онд санд төвлөрсөн нийт орлогын 75.4 хувийг ХЭДС-аас авсан санхүүжилт, 2.5 хувийг Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”, 17.2 хувийг санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, 2.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого , бусад эх үүсвэр 2.7 хувийг эзэлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцон төсвийн төсөл хүргүүлдэг ч ХХҮЕГ-аас төсвийн хуваарийг өөрчлөн ирүүлдэг байна.

**2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг оновчтой зөв хуваарилаагүй байна.**

ХХҮЕГ-аас хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга болон мэргэжилтнүүдээс санал авч өнгөрсөн хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага багатай арга хэмжээнүүдийг хэлэлцэж дараагийн төсөл, хөтөлбөр батлахад анхаарч хэрэгжээгүй, үр дүн багатай арга хэмжээнд дүгнэлт хийж үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт хийдэг байна.

Төсөл хөтөлбөрүүдэд батлагдсан санхүүжилтийг хуваарилахдаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн сумуудын хөдөлмөр эрхлэлт хариуцсан байцаагч нараас хэрэгцээний судалгаа авч, хэрэгцээг тодорхойлдог байна.

Сумуудад шаардагдах санхүүгийн нөөцийг тодорхойлж хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр хэлэлцэн баталж сумуудад хуваарилдаг бөгөөд,сумаас ирсэн хэрэгцээг үндэслэн нийт ажил хийх насны иргэдийн тоонд харьцуулж хуваарилдаггүй,зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн удирдлагын саналаар хуваарилалт хийж байгаа нь оновчтой зөв хуваарилалт хийж байна гэх үндэслэлгүй байна.

**3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдааг холбох аймгийн салбар зөвлөл нь дүрэмд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна**

**3.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө харилцан уялдаагүй байна.**

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Шинээр 4000 мянган ажлын байр бий болгож, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангана” гэж тусгасан байна.

2021-2022 оны төлөвлөгөөнд

- ✓ Ажил эрхэлдэггүй мэргэжлийн сургалтад хамрагдаагүй залуучуудын нийт хүн амд эзлэх хувийг бууруулна
- ✓ Аймгийн ажиллах хүчний оролцооны түвшнийг нэмэгдүүлнэ
- ✓ Боловсон хүчнийг ажлын байрны захиалгад нийцүүлэн сургаж ажилгүйдлийн түвшнийг бууруулна
- ✓ Хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хөдөлмөр эрхлэлтийн хувийг нэмэгдүүлнэ
- ✓ Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийг цахимжуулж ашиглалтыг нэмэгдүүлнэ
- ✓ Аймгийн хэмжээнд хувийн хэвшилд ажиллагсдын тоог нэмэгдүүлнэ
- ✓ Ядуурлын үндэсний түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувийг бууруулна гэж тусгажээ.

- ✓ Энэ чиглэлээр ХХҮГ-ын 2016-2021 оны ажлын төлөвлөгөөнд

- ✓ Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний ажил үйлчилгээг хэрэгжүүлэх
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- ✓ Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчтой холбож, ажлын байранд зуучлах
- ✓ Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох иргэдийн орлогыг нэмэгдүүлэх
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэн хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлнэ гэсэн зориулалтыг хүрээнд ажлуудыг тусган төлөвлөжээ.

Аудитаар дээрх газруудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрхэн уялдаж байгааг хянахад төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа бодлоготой уялдаагүй, хэт ерөнхий асуудлыг төлөвлөгөөнд тусгасан байна.

### 3.2 Аймгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд бүс нутгийн онцлогийг харгалзан үзсэн асуудлыг тусган оруулаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр Аймгийн Засаг даргын 2016-2020, 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд бүс нутгийн онцлогийг харгалзан үзсэн асуудлыг тусган оруулаагүй байна.

### 3.3 Аймгийн салбар зөвлөл нь дүрэмд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй байна

Зөвлөл аймаг орон нутгийн ИТХ, ЗДТГ болон хөдөлмөрийн хэлтсийг холбосон гүүр бөгөөд хөдөлмөрийн асуудлаар тухайн орон нутагт хийгдэх

бодлого, үйл ажиллагаанд төр, ажил олгогч байгууллага, үйлдвэрчний эвлэл, иргэний төлөөллийг оролцуулан нийгмийн зөвшлийн хуралдааны хэлбэрийг ашиглан хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдэд аль суманд хэчнээн иргэд, аж ахуйн нэгжийг хамрагдах квотыг тогтоож, зохих зөвлөмжийг өгч ажилладаг нийгмийн зөвшлийн байгууллага болно.

Аймгийн салбар зөвлөл нь жилд 1-2 удаа хуралдан салбарын төлөвлөгөө, зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь,хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр арга хэмжээнд хамрагдах сумдын хуваарийг батлан ажилладаг байна.

Аудитын явцад салбар зөвлөлийн 2016-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хийсэн ажлын тайланг шалгахад, 2018 онд 18 ажил, 2019 онд 12 ажил, 2021 онд 12 ажил хийхээр төлөвлөн ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг 2018 онд тооцож, бусад онуудад биелэлтийг тооцоогүй, 2016, 2017, 2020 онуудад хийх ажлын төлөвлөгөөгүй ажиллажээ.

Аудитад ирүүлсэн ажлын тайлан, хурлын тэмдэглэлүүдийг хянахад салбар зөвлөл нь ХХҮГ-аас ирүүлсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, хөтөлбөрүүдийн сумдад хуваарилсан хуваарийг баталснаас өөрөөр дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

**3.4 Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх талаар гарсан дээд газраас хэрэгжүүлэх тусгайлсан төлөвлөгөө байхгүй, хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн чиглэлийг өгч ажиллаагүйн улмаас төлөвлөгөө гаргаагүй байна.**

2016-2020 онд хэрэгжсэн, Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд орон нутагт хөдөлмөр эрхлэлтийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага болох ХХҮГ нь дээд байгууллагаас ирсэн чиглэлийн хүрээнд өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлж, харин хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлд тусгайлан анхаарч төлөвлөгөө гарган ажилласан зүйл байхгүй байна.

Бодлогыг хэрэгжүүлэхэд орон нутгийн Засаг даргын хувьд дээд газраас хэрэгжүүлэх тусгайлсан төлөвлөгөө байхгүй, хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн чиглэлийг өгч ажиллаагүйн улмаас төлөвлөгөө гаргаагүй байна.

## БҮЛЭГ 2. ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖИЛГҮЙДЛИЙГ БУУРУУЛАХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНД ТАВИХ ХЯНАЛТ ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ БАЙНА.

**4. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үр дүнтэй сайн хэрэгжүүлсэн ч, үр дүнг тооцож ажиллаагүй байна.**

**4.1 Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн ч үр дүнг тооцож ажиллаагүй байна**

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

***1.Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ***:

2016-2021 онд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг нийтдээ 5521 иргэнд үзүүлж, үүнээс ганцаарчилсан зөвлөгөөнд 1935, бүлгээр зөвлөгөө өгөх үйлчилгээнд 3586 иргэн хамрагдсан байна.

Тайлант онуудад нийт 1935 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлснээс мэдээлэл авсан иргэдийн хэдэн хувь нь ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдаж, ажилд зуучлагдаж, мэргэжлийн түр сургалт, нийтийг хамарсан ажилд хамрагдсан, түр болон байнгын ажлын байртай болсныг тандан гаргасан судалгааг хийдэггүй байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгээр зөвлөгөө өгөх үйлчилгээг ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчид болон ажилгүй, ажил хайж байгаа иргэд, МСҮТ-ийн төгсөгчид зэрэг нийт 3586 иргэнийг хамруулсан байна.

Бүлгээр зөвлөгөө өгөх үйлчилгээг эдгээр онуудад “Их үйлсийн Бүтээмж” ТББ, “Мөнх ирээдүйн ундарга” ХХК-ний дэргэдэх хувийн хөдөлмөрийн бирж, Монголын мэргэшсэн зөвлөхүүдийн холбоо ТББ зэрэг газруудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, гэрээг дүгнэн биелэлтийг тооцон ажиллажээ.

Хөдөлмөрийн зах зээлд хөл тавьж байгаа залуучуудыг идэвхжүүлэхэд чиглэсэн, ажил идэвхтэй хайж байгаа залуучууд, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн, хэд хэдэн шинэлэг үйлчилгээ, арга хэрэгслийг нэвтрүүлэх зорилготой үе шаттай модуль сургалтыг 14 удаа зохион байгуулж 185 залуусыг хамруулсан байна.

*График №1 Зуучлал, онд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ*




***2.Ажилд зуучлах үйлчилгээ:*** 2016-2021 онд ажилд зуучлах үйлчилгээг 5321 иргэнд үзүүлж,түр болон байнгын ажлын байранд зуучилжээ. Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй 4347 аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогч хувь хүнээс 7480 ажлын байрны захиалга ирүүлснийг ажил хайгч иргэдэд уламжилж, ажилд зуучлах үйлчилгээнд 6537 иргэн хамрагдсанаас 5321 иргэнийг өөрт нь тохирох түр болон байнгын ажлын байранд зуучилсан байна.

*График №2. Зуучлах үйлчилгээ*

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**




Ажлын байранд зуучлагдан орсон иргэдийг байнгын ажлын байрандаа тогтвор суурьшилтай ажиллаж байгаа эсэхэд тандалт судалгаа хийдэггүй байна.

**4.2 Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн үйл ажиллагаа нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна**

Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем болох LMIS программд ажил хайгч иргэн, ажил олгогч, ажлын байрны захиалга, шинэ ажлын байрны бүртгэл, ажлаас чөлөөлөгдсөн ажилгүйдлийн тэтгэмж авах иргэн, ХЭДС-ын төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэд, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөрт хамрагдсан иргэд, албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар мэдээллийг оруулан бүртгэж ажилладаг байна.

Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системд оруулсан мэдээллээс түүвэрлэн ажил олгогч, болон ажил хайгч, ХЭДС-ийн төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн нийт тоон мэдээллийг  статистикаар гарсан тоон мэдээлэлтэй тулгахад зөрүү илрээгүй.

Энэ программ нь 2016 оноос хойш шинэчлэл хийгдээгүй, хурд нь шаардлагын хэмжээнд хүрдэггүй мэдээлэл оруулахад гацах тохиолдол их гардаг, программаас гарах мэдээллүүд нь хоорондоо харилцан уялдаа холбоогүй зэрэг сул талуудтай байна.

**4.3 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг бодитой тооцож, зардлыг 19.7 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.**

2016-2021 онуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх мэдээллээр хангах үйлчилгээг 5551 иргэнд хүргэж нийт 42.8 сая төгрөгийг, ажилд зуучлах үйлчилгээг 5321 иргэнийг хамруулж, 17.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

*Хүснэгт №3. Зөвлөх үйлчилгээ*

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

| № | Он | Ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээ | | Бүлгээр зөвлөгөө өгөх үйлчилгээ | | Ажилд зуучлах үйлчилгээ | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хамрагдсан иргэний тоо | Зарцуулсан зардал | Хамрагдсан иргэний тоо | Зарцуулсан зардал | Хамрагдсан иргэний тоо | Зарцуулсан зардал |
| 1 | 2016 | 445 | 5,340.0 | | | 720 | 87.4 |
| 2 | 2017 | 550 | 6,167.0 | 825 | 4,950.0 | 1104 | 836.6 |
| 3 | 2018 | 517 | 4,799.4 | 683 | 4,014.0 | 1105 | 7332.7 |
| 4 | 2019 | 200 | 2,400.0 | 1171 | 7,026.0 | 1007 | 5577.5 |
| 5 | 2020 | | | 152 | 912.0 | 744 | 1021.7 |
| 6 | 2021 | 223 | 2,676.0 | 755 | 4,530.0 | 641 | 2665.5 |
| **Нийт дүн** | | **1935** | **21,382.4** | **3586** | **21,432.0** | **5321** | **17521.4** |

Хөдөлмөр эрхлэлтийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх ажил зуучлал хариуцсан мэргэжилтэн нь ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээг өгдөг бол, бүлгээр зөвлөгөө өгөх үйлчилгээг гэрээний үндсэн дээр Их үйлсийн Бүтээмж" ТББ, "Мөнх ирээдүйн ундарга" ХХК-ний дэргэдэх хувийн хөдөлмөрийн бирж, Монголын мэргэшсэн зөвлөхүүдийн холбоо ТББ зэрэг газруудаар гүйцэтгүүлжээ.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх мэдээллээр хангах үйлчилгээнд гарсан зардлыг 1 хүнд ногдох норматив хэмжээтэй нь харьцуулахад зөрүү илрээгүй, харин ажилд зуучлах үйлчилгээний норматив зардлаас 19,7 сая төгрөгийн төсвийг хэмнэсэн эерэг үзүүлэлттэй байгаа хэдий ч үйл ажиллагааны хувьд ажилд зуучлах үйлчилгээг хангалттай бүрэн дүүрэн хийгээгүй байна.

## 5. Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний явц болон гүйцэтгэлд тавих хяналт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна

### 5.1 2016-2021 онуудад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр гадаад болон дотоодын зээл, тусламж, бүх төрлийн сан, олон улсын байгууллагаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт дунджаар 80,5 хувьтай байна.

Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлөөс 2016 онд хэрэгжүүлэхээр 6 хөтөлбөр арга хэмжээг,2017- 2020 онуудад 2 хөтөлбөрийг нэмж баталсан байна.

Хөтөлбөрүүдийн үр дүнг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №4 Хөтөлбөр*

| № | Он | Төсөл хөтөлбөр | Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих | Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | Нийтийг хамарсан ажил зохион байгуулах | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих | Ажлын байрыг дэмжих хөтөлбөр | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2016-2021 | Нэмэгдсэн ажлыг байр /6 сараас дээш/ | 499 | 182 | 75 | | | 20 | 1893 | 139 | 2808 |
| | | Нэмэгдсэн ажлыг байр /6 сараас доош/ | | 21 | 211 | 341 | 1312 | 221 | 235 | 37 | 2378 |

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

2016-2021 онуудад хэрэгжсэн дээрх хөтөлбөр, арга хэмжээнд нийт 7,253 иргэн хамрагдаж, 2808 байнгын ажлын байр, 2378 түр ажлын байр бий болсон байна.

## Гадаадын зээл тусламж

МУ-ын засгийн газар, Орон Улсын Хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан санхүүгийн хэлэлцээрийн дагуу орон нутгийн зорилтот бүлгийн тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих зорилготой “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийг Орон нутгийн санаачилгын төслийн хүрээнд 2020, 2021 онуудад Дэлхийн хөгжлийн банкны санаачилгаар “ хэрэгжүүлсэн байна.

“Хөдөлмөрийн зах зээлд шилжихэд нь илүү саад, бэрхшээл учирч буй ажилгүй иргэдийг дэмжих хөдөлмөр эрхлэлтийг цогц сургалт, бичил бизнесийн хөгжлийг дэмжих шинэлэг үйлчилгээ, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх шинэлэг арга замыг турших”-хөтөлбөрийн зорилгын хүрээнд:

*Хүсэнгт №5. Хөтөлбөрт зориулан олгосон санхүүжилт, зарцуулалт, хөтөлбөрт хамрагдсан иргэд, буцаан төвлөрүүлэлтийн судалгаа /сая төгрөгөөр/*

| № | Төсөл, хөтөлбөрийн нэр | 2020 он | | | | 2021 он | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Авсан санхүүжилт | Хөтөлбөр арга хэмжээнд олгосон /сая төгрөг/ | Буцаан төвлөрүүлсэн | Хамрагдсан иргэн | Авсан санхүүжилт | Хөтөлбөр арга хэмжээнд олгосон /сая төгрөг/ | Буцаан төвлөрүүлсэн | Хамрагдсан иргэн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөр ДЭЛХИЙН БАНК | 73.2 | 6.0 | 67.2 | 160 | 103.9 | 24.6 | 79.30 | 184 |

Хөтөлбөрийн хүрээнд 2020 онд 2 удаагийн сургалт зохион байгуулан ажиллажээ.
Сургалтыг аймгийн ХХҮГазар “Потеншил” боловсрол сургалтын төв-тэй хамтран оролцогсдын сэтгэл зүй харилцаа хандлагыг өөрчлөх, иргэдийг ажлын байранд зуучлах, залуучуудын сүлжээ байгуулах чиглэлээр 50 иргэнийг хамруулан тус бүрдээ 20 гаруй гишүүнтэй 2 facebook групп нээн, Спорт өдөрлөг зохион байгуулан төслөөс 4,7 сая төгрөгийг, гэрээт ажилтны цалин хөлсөнд 1,3 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

2021 онд Ажил олгогч, түр ажил хайж буй залуучуудын гурвалсан уулзалтыг Улиастай, Тосонцэнгэл сумдад харилцаа хандлагаа өөрчлөх, ажил амьдралын тэнцвэр, хөдөлмөрт бэлтгэх 5 удаагийн сургалтыг зохион байгуулан 184 иргэнийг

оролцуулан 19,8 сая төгрөгийг, төслийн гэрээт ажилтны цалин хөлсөнд 4,8 тус тус зарцуулсан байна.

Төслийн хэрэгжилт 17,3 хувьтай хэрэгжиж, коронавируст халдвар ихэссэн, хөл хорио тогтоосон зэрэгтэй холбоотой төслийн үйл ажиллагаа дуусгавар болсон байна.

Авсан санхүүжилтээс 2020 онд 67,2 сая төгрөгийг, 2021 онд 79,3 сая төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлжээ.

## Сум хөгжүүлэх сангийн зээл

Сум хөгжүүлэх сан нь аймгийн хэмжээгээр 2021 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар 4,862.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

*График №3. Зээлийн авлагын үлдэгдлийг сумдаар харуулбал дараах байдалтай байна.*




Өөрийн санаачилгаар 2020 онд сумдын сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийгдсэн нийцлийн аудитаар хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг эргэн төлүүлэх үүргийг сумдын Засаг дарга нарт зөвлөмж, албан шаардлагаар хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулж ажилласантай холбоотойгоор зээлийн эргэн төлөлт 2021 онд 28 хувиар нэмэгдсэн байна.

*Хүснэгт № 6. Авлагын сүүлийн 3 жилийн судалгаа*

| Тайлант он | Авлагын эхний үлдэгдэл /сая.төг/ | Зээл олголт /сая.төг/ | Эргэн төлөлт /сая.төг/ | Авлагын эцсийн үлдэгдэл /сая. төг/ | Эргэн төлөлтийн эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| 2019 он | 5,063.6 | 1,435.6 | 1,064.4 | 5,434.8 | 21% |
| 2020 он | 5,434.8 | 1,397.8 | 1,384.0 | 5,448.3 | 25.4% |
| 2021 оны эхний 11 | 5,448.3 | 1,185.0 | 1,771.0 | 4,862.3 | 32.5% |

| сарын байдлаар | | | | | |
|---|---|---|---|---|---|

Дээрх судалгаанаас харахад сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

2021 онд сум хөгжүүлэх сангийн программын зээлийн үлдэгдлийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн сантай холбосон нь зээлийн барагдуулалтад ач холбогдлоо өгчээ.

## Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгосон зээл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан арга хэмжээнүүдийг зорилтот бүлгүүдэд чиглүүлэн банкаар дамжуулан бичил бизнес эрхлэгчдэд ажлын байр бий болгоход зориулж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санаас жижиг зээл олгодог байна.

2017-2018 онд аймагт үйл ажиллагаа явуулж 10 аж ахуйн нэгж, 1 хоршоо, 1 иргэнд  нийт 1,477.2 сая төгрөгийн зээлийг олгожээ.

*Хүснэгт №7. ЖДҮХС-аас олгосон зээлийн судалгаа 2019*

| Д/д | Аж ахуйн нэгжийн нэр | Үйл ажиллагааны чиглэл | Олгосон санхүүжилт /сая төгрөг/ | Ажиллаж байгаа ажилчид | Хаяг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үр Ор ХХК | Талх, нарийн боов, худалдаа үйлчилгээ, оёдол | 200.0 | 12 | Их-Уул сум Баян-Ухаа баг |
| 2 | Булган сор хишиг ХХК | Арьс шир боловсруулах | 120.0 | 6 | Улиастай сум Жинст баг МУИС-ийн доод хэсэг 5-7 тоот |
| 3 | Манлай баян ургац ХХК | Хиам сосиск, мах бүтээгдэхүүн боловсруулах | 200.0 | 10 | Улиастай сум Богдын гол баг / |
| 4 | Энэрэлт байгаль ХХК | Зөөлөн оёдол | 100.0 | 12 | Улиастай сум Жинст |
| 5 | Эрхэт тунамал ХХК | Ноос боловсруулах, дулаалгын материал үйлдвэрлэл | 200.0 | 7 | Улиастай сум Өлзийт баг |
| 6 | Иргэн М.Базарсад | Тоосго блок | 150.0 | 7 | Улиастай Жинст баг ногоочдын |
| 7 | Агьт сүүн далай хоршоо | Фермерийн үйл ажиллагаа | 28.0 | 4 | Алдархаан сум, Алдар баг |
| **Дүн** | | | **998.0** | **58** | |

2020 онд ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас хуваарилагдсан 479.,2 сая төгрөгийг 5 ААН-ийн үйл ажиллагааг дэмжин 23 ажлын байр нэмэгдүүлэхээр олгосон байна.

*Хүснэгт № 8. ЖДҮХС-аас олгосон зээлийн судалгаа 2020 он*

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

| Д/д | Аж ахуйн нэгжийн нэр | Үйл ажиллагааны чиглэл | Олгосон санхүүжилт /сая төгрөг/ | Ажиллаж байгаа ажилчид | Хаяг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнхөд мандаг ХХК | Хүнсний үйлдвэрлэл | 200.0 | 10 | Улиастай сум Өлзийт баг үйлдвэрийн хэсэг |
| 2 | Мөнххэдрэг ХХК | Гутал үйлдвэрлэл | 45.0 | 4 | Улиастай сум Богдын гол баг МСҮТ-ийн урд |
| 3 | Хадан суурь мөнх ХХК | Оймс үйлдвэрлэл | 84.9 | 5 | Улиастай сум Жинст баг хими цэвэрлэгээний |
| 4 | Буян-Арвижих түмэн ХХК | Жимс, жимсгэнэ боловсруулах | 99.3 | 3 | Тосонцэнгэл сум |
| 5 | Анх энэрлэн ХХК | Дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 50.0 | 3 | Улиастай сум Жинст баг "Хүннү" өглөөний зоог |
| **Дүн** | | | **479.2** | **25** | |

Аудитын явцад зарим төслүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцахад шинээр болон хадгалагдсан 83 ажлын байрыг бий болгосон, үйл ажиллагаанууд нь хэвийн явагдаж байна.

**Бичиг бизнес эрхлэгчдийг дэмжих зээл**

Бичиг бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр Төрийн банкны салбараар дамжуулан ХЭ-ийн салбар зөвлөлийн шийдвэрээр 2018 онд 28 иргэнд 310,0 сая төгрөгийн, 2019 онд 42 иргэнд 395,0 сая төгрөгийн, 2018 онд Дэлхийн банкны санхүүжилтээр Хаан банкны салбараар дамжуулан 3 иргэнд 75,0 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

2022 оны 4 сарын 14-ны байдлаар Хаан банкинд 3 иргэний 17,8 сая төгрөгийн, Төрийн банкинд 11 иргэний 23,9 сая төгрөгийн зээл хэвийн төлөлттэй байна.

## 5.2 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хэлэлцэн дүгнээгүй байна.

*Хүснэгт №9. Хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн судалгаа 2016-2021 он сая төгрөг*

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

| № | Он | Төсөл хөтөлбөр | Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гараана бизнесийг дэмжих | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих | Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | Нийтийг хамарсан ажил зохион байгуулах | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих | Ажлын байрыг дэмжих хөтөлбөр | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2016 | Төлөвлөгөө | 103.4 | 83.5 | 92.3 | 321.7 | 110.8 | 204.3 | | | 916.00 |
| | | Гүйцэтгэл | 45.1 | 30.8 | 76.2 | 225.0 | 101.0 | 160.3 | | | 638.40 |
| | | Хамрагдсан иргэн | 169 | 34 | 158 | 51 | 712 | 380 | | | 1,504.00 |
| | | Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг | | | | 119.0 | | | | | 119.00 |
| 2 | 2017 | Төлөвлөгөө | 42.2 | 71.5 | 92.9 | 297.6 | | | 460.1 | 34.1 | 998.40 |
| | | Гүйцэтгэл | 41.6 | 58.5 | 60.7 | 293.5 | | | 404.8 | 30.1 | 889.20 |
| | | Хамрагдсан иргэн | 181 | 112 | 152 | 146 | | | 1020 | 60 | 1,671.00 |
| | | Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг | | 56.0 | 51.0 | 275.0 | | | 180.0 | 10.0 | 572.00 |
| 3 | 2018 | Төлөвлөгөө | 37.4 | 112.6 | 85.3 | 315.0 | | | 363.1 | 31.2 | 944.60 |
| | | Гүйцэтгэл | 28.9 | 91.1 | 59.1 | 290.9 | | | 346.5 | 30.4 | 846.90 |
| | | Хамрагдсан иргэн | 237 | 153 | 130 | 231 | | | 707 | 35 | 1,493.00 |
| | | Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг | | 86.0 | 50.0 | 277.0 | | | 183.0 | 15.0 | 611.00 |
| 4 | 2019 | Төлөвлөгөө | 20.6 | 231.2 | 76.4 | 329.7 | | | 516.4 | 41.3 | 1,215.60 |
| | | Гүйцэтгэл | 20.5 | 212.9 | 61.8 | 288.5 | | | 486.3 | 40.9 | 1,110.90 |
| | | Хамрагдсан иргэн | 150 | 240 | 128 | 170 | | | 650 | 31 | 1,369.00 |
| | | Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг | | 200.0 | 55.0 | 270.0 | | | 270.0 | 27.0 | 822.00 |
| 5 | 2020 | Төлөвлөгөө | 15.6 | 120.7 | 82.8 | 221.1 | | | 527.3 | 41.8 | 1,009.30 |
| | | Гүйцэтгэл | 10.4 | 119.8 | 78.1 | 110.1 | | | 318.4 | 31.1 | 667.90 |
| | | Хамрагдсан иргэн | 136 | 79 | 45 | 194 | | | 413 | 22 | 889.00 |
| | | Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг | | 110.0 | 37.5 | 104.0 | | | 235.0 | 24.0 | 510.50 |
| 6 | 2021 | Төлөвлөгөө | 21.6 | 40.6 | 122.8 | 235.7 | | | | 49.3 | 470.00 |
| | | Гүйцэтгэл | 12.9 | 18.0 | 98.1 | 234.1 | | | | 48.9 | 412.00 |
| | | Хамрагдсан иргэн | 128 | 2 | 66 | 103 | | | | 28 | 327.00 |
| | | Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг | | | 44.0 | 229.0 | | | | 27.0 | 300.00 |
| 7 | Нийт дүн | **Төлөвлөгөө** | **240.8** | **660.1** | **552.5** | **1,720.8** | **110.8** | **204.3** | **1,866.9** | **197.7** | **5,553.90** |
| | | **Гүйцэтгэл** | **159.40** | **531.10** | **434.00** | **1,442.10** | **101.00** | **160.30** | **1,556.00** | **181.40** | **4,565.30** |
| | | **Хамрагдсан иргэн** | **1001** | **620** | **679** | **895** | **712** | **380** | **2790** | **176** | **7,253** |
| | | **Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг** | **-** | **452.0** | **237.5** | **1,274.0** | **-** | **-** | **868.0** | **103.0** | **2,934.50** |
| | | **Хугацаа хэтэрсэн санхүүгийн дэмжлэг** | | | **42.6** | **218.3** | | | **244.1** | **24.2** | **529.20** |
| 2016-2021 он | | **Нэмэгдсэн ажлыг байр** /6 сараас дээш/ | **499** | **182** | **75** | | | **20** | **1893** | **139** | **2808** |
| | | **Нэмэгдсэн ажлыг байр** /6 сараас доош/ | | **21** | **211** | **341** | **1312** | **221** | **235** | **37** | **2378** |

2016-2021 онуудад тус сангийн зарлагын 2,934.5 сая төгрөг буюу 64,2 хувийг эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт, 1,630.8 сая төгрөг буюу 35,8 сая төгрөгийг бусад хөтөлбөрүүдэд зарцуулжээ.

Санхүүгийн дэмжлэгийн 1,274,0 сая төгрөг буюу 43,4 хувь нь малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 868,0 сая төгрөг буюу 29,6 хувийг ажлын байрыг дэмжих хөтөлбөрт тус тус олгосон боловч хөтөлбөрийн үр дүнг тооцон ажилладаггүй байна.

2021 оноос орон нутагт залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд "Шилдэг Старт-Ап" нэртэй хөтөлбөрийг хэрэгжүүлж 1 багийг сонгон шалгаруулж 10,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон нь шинэ ажлын эхлэл байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг аудитын явцад тодруулан, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, он оны хэрэгжилтийн тайлан, ХХҮГ-ын жил бүрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлан, ХХҮГ-ын дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний хийсэн хяналтын тайлангуудыг судлан дүн шинжилгээ хийлээ.

- ✓ Хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн үр дүнд тавих хяналт, зөвлөгөө өгөх ажил хангалтгүй
- ✓ 2016, 2017, 2018 онуудад олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт гэрээт хугацаанаасаа 3-4 жилээр хэтэрсэн

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

- ✓ Санхүүгийн дэмжлэг авсан иргэдээс гүйцэтгэлийн тайлан авдаггүй
- ✓ Жил бүр хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн үр дүнг хэлэлцүүлж, тайлан гаргаагүй зөрчил дутагдал байна.

Аудитаар хөтөлбөрүүдийн хэрэгжилтүүдийг дунджаар 80,5 хувь байна гэж дүгнэлээ.

### 5.3 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 2016-2021 онуудад хэрэгжээгүй байна

### 6.1 ХЭДС-ийн орлогыг хууль, журмын дагуу бүрэн төвлөрүүлсэн байна

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2016-2021 онд байдлаар санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 1,229.8 сая төгрөгийг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулаагүй аж ахуйн нэгж байгууллагуудаас төлсөн төлбөр 148,4 сая төгрөгийг, хөтөлбөр арга хэмжээний үлдэгдэл 294,9 сая төгрөгийг нийт 1,673.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт №10*Төвлөрүүлсэн орлогын судалгааг он тус бүрээр харуулбал: / сая төгрөгөөр/

| № | Төвлөрүүлсэн орлогын | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | 2021 он | Нийт төвлөрүүлсэн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Эргэн төлөлтөөс | 60.3 | 76.7 | 129.5 | 312.2 | 303.7 | 347.4 | 1229.8 |
| 2 | Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлсөн төлбөр | 5.4 | 6.2 | 0.4 | 33.4 | 103 | - | 148.4 |
| 3 | Хөтөлбөр арга хэмжээнээс | 7.5 | 1.6 | 66.1 | 8.8 | 68.7 | 142.2 | 294.9 |
| **Дүн** | | **73.2** | **84.5** | **196** | **354.4** | **475.4** | **489.6** | **1673.1** |

ХЭДС болон халамжийн сангийн 2019 оны үйл ажиллагааны үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг эргэн төлүүлэх зөвлөмжийг ХХҮГ-ын даргад хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулж ажилласантай холбоотойгоор зээлийн эргэн төлөлт жил бүр нэмэгдсэн байна.

### 6.2 ХЭДС-ийн хөрөнгийг журмын дагуу зарцуулсан байна.

Улсын төсвөөс баталсан ХЭДС-ийн хөрөнгийг жил бүр аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн шийдвэрээр тухай жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд хуваарилдаг байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөтөлбөр арга хэмжээнд зориулан 2016-2021 онд нийт 5.553,9 сая төгрөгийг, 2021 онд цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 400,9 сая төгрөгийг нийт 5,954.8 сая төгрөгийг баталсан байна.

Төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ 3 үе шаттай сонгон шалгаруулалтыг явуулсан байна.

- ✓ Ирүүлсэн төслүүд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг нягталсан
- ✓ Шаардлага хангасан төслүүдийн үйл ажиллагаатай танилцсан
- ✓ Шалгарсан төслүүдийг хөтөлбөр тус бүрийн томилогдсон ажлын хэсгээр хэлэлцүүлэн сонгон шалгаруулалтыг хийжээ.

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

Сангийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.1-д заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 2016-2021 онуудад нийт 4,565.3 сая төгрөгийг зарцуулжээ.

Аудитын явцад ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалт, бүртгэлтэй холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

*Хүснэгт № 11Сангийн хөрөнгийн бүртгэлийн судалгаа 2016-2021 он /сая төгрөг/*

| № | Он | Төсөл хөтөлбөр | Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гараанй бизнесийг дэмжих | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих | Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | Нийтийг хамарсан ажил зохион байгуулах | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих | Ажлын байрыг дэмжих хөтөлбөр | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Нийт дүн | Төлөвлөгөө | 240.8 | 660.1 | 552.5 | 1,720.8 | 110.8 | 204.3 | 1,866.9 | 197.7 | 5,553.90 |
| | | Гүйцэтгэл | 159.40 | 531.10 | 434.00 | 1,442.10 | 101.00 | 160.30 | 1,556.00 | 181.40 | 4,565.30 |
| | | Хамрагдсан иргэн | 1001 | 620 | 679 | 895 | 712 | 380 | 2790 | 176 | 7,253 |
| | | Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг | - | 452.0 | 237.5 | 1,274.0 | - | - | 868.0 | 103.0 | 2,934.50 |
| | | Хугацаа хэтэрсэн санхүүгийн дэмжлэг | | | 42.6 | 218.3 | | | 244.1 | 24.2 | 529.20 |

## 7. Хүүхдэд ноогдох хичээл үйлдвэрлэлийн зардлыг бага баталж байгаа нь хөдөлмөрийн зах зээлд мэргэшсэн сайн ажилтан бэлтгэгдэн гарч байгаа нь эргэлзээтэй байна

### 7.1 Элссэн суралцагчдын 6,5 хувь тэтгэлэг аваад боловсрол эзэмшээгүйгээс МБСДС-ийн 53.5 сая төгрөг үр дүнгүй зарцуулагдсан байна.

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасны дагуу суралцагчид олгох тэтгэлгийг мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлнэ гэж заажээ. Мэргэжилийн боловсролын сургууль нь суралцагчийн тухайн сарын үнэлгээ, ирцийн мэдээллийг мэргэжлийн боловсрол, сургалтын нэгдсэн цахим системд бүртгэсний дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам хянаж нэгтгэж,сангийн яамнаас хуваарилалт хийж, суралцагчийн тэтгэлгийн мөнгийг банкин дахь харилцах дансанд нь шилжүүлдэг байна. 2016-2021 онуудад тэтгэлэгт нийт суралцагчд хамрагдсан байна.

Аудитаар тэтгэлгийг 2019-2021 онд элсэн суралцагчийн нэрсийн жагсаалт баталсан тушаалыг, төгсөгчдийн нэрсийг баталсан тушаалыг, ангийн журналыг www.mergejil.mn мэдээллийн нэгдсэн системд бүртгэлтэй тэтгэлэг олгосон суралцагчийн жагсаалттай тулгалт хийж түүвэрчлэн шалгалаа.Шалгалтаар 2019-2020 он 2020-2021 оны хичээлийн жилүүдэд 1-8 сар тэтгэлэгт хамрагдан төгсөөгүй сургуулиа орхисон нийт 117 суралцагчид 53.5 сая төгрөгийн тэтгэлэг авсан зөрчил илэрлээ.

### 7.2 МБС-ын байгууллагын санхүүжилт үр нөлөөтэй байна уу?

***Завхан аймаг дахь Политехникийн коллеж***

Завхан аймаг дахь Политехникийн коллеж нь 2016-2021 онд батлагдсан 79-80 орон тоотойгоор, 1 жилд 544-746 суралцагчтай үйл ажиллагаагаа явуулжээ..

2016-2021 онд төсвийн төлөвлөгөөгөөр нийт 10.227,7 сая төгрөгийг зарцуулахаас 10.051,7 сая төгрөг буюу 97.8 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж, зардлыг 176.0 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

Хүснэгт № 12. *Завхан аймаг дахь Политехникийн коллежийн төсвийн төлөвлөгөө,гүйцэтгэл*

| Зардлын зүйл анги | 2,016 | | 2017 | | 2018 | | 2019 | | 2020 | | 2021 | | Нийт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 774.5 | 774.5 | 781.7 | 777.3 | 803.1 | 797.4 | 958.4 | 911 | 1140.4 | 1071 | 1143 | 1131.4 | **5,600.9** | **5,462.7** | **138.20** |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 88.2 | 88.2 | 84.3 | 84.3 | 92.9 | 92.9 | 121 | 117 | 154 | 127 | 158 | 157.9 | **698.4** | **667.4** | **31.00** |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 378.9 | 378.9 | 334.9 | 334.9 | 340 | 335.7 | 343 | 343 | 377 | 376 | 380 | 380 | **2,153.8** | **2,148.0** | **5.80** |
| Хангамж, бараа материалын зардал | 17.7 | 17.7 | 16.1 | 16.2 | 18.7 | 18.7 | 16.7 | 16.7 | 34.4 | 34.4 | 18.7 | 18.7 | **122.3** | **122.4** | **(0.10)** |
| Нормативт зардал | 62.3 | 61.9 | 47.2 | 43.2 | 44.4 | 43.5 | 50 | 49.6 | 46.5 | 33.8 | 39.4 | 37.5 | **289.8** | **269.5** | **20.30** |
| Эд хогшил худалдан авах | 3.2 | 2.2 | 3.6 | 3.6 | 7.6 | 7.5 | 35.6 | 35.6 | 17.7 | 17.7 | 2.2 | 2.2 | **69.9** | **68.8** | **1.10** |
| Томилолт, зочны зардал | 4.2 | 4.2 | 5 | 5 | 7 | 6.7 | 5 | 5 | | | | | **21.2** | **20.9** | **0.30** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 37.6 | 35.7 | 45.1 | 45.1 | 49.9 | 48.9 | 49.9 | 47.8 | 27.4 | 22.7 | 45.2 | 44 | **255.1** | **244.2** | **10.90** |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 97.0 | 94.1 | 98 | 98 | 98 | 98 | 98 | 98 | 64 | 64 | 64.5 | 64.5 | **519.5** | **516.6** | **2.90** |
| Бусад урсгал шилжүүлэг | 93.0 | 83.8 | 61.8 | 61.6 | 121.3 | 121.3 | 60.3 | 60.3 | 119.7 | 118 | 85.7 | 85.7 | **541.8** | **530.7** | **11.10** |
| **Нийт төсөв** | **1,556.6** | **1541.2** | **1478** | **1469.2** | **1583** | **1570.6** | **1738** | **1684** | **1981.1** | **1864** | **1937** | **1921.9** | **10,272.7** | **10,051.2** | **221.50** |

Гүйцэтгэлээр цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал, зардалд, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бусад урсгал шилжүүлгийн зардлууд хэмнэгдсэн байна.

Цалин хөлс 138.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь төсвийг төлөвлөхдөө багш нарт олгох цалинг анги дүүргэлтийг 15 хүүхдээр тооцож хүргүүлдэг бол цалинг нь олгохдоо анги дүүргэлт нь хангалтгүй бол хүүхдийнх тооноос хамаарч хувилж боддогтой холбоотой байна.

Аудитаар хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг сонгон авч үзлээ. Зардлын гүйцэтгэлийг тухайн хичээлийн жилд суралцаж байгаа нийт суралцагчдын тоонд харьцуулахад  нэг суралцагчид жилд 127,7 мянган төгрөг, 1 сард 15,9 мянган төгрөг ногдож байна.

Мэргэшсэн ажилтан бэлтгэхэд онолын мэдлэгийг, танхимаар 30 хувийг ,дадлага ажлаар 70 хувийн мэдлэгийг олж авдаг байна.

Эндээс дүгнэлт хийхэд хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал нь хүрэлцэхгүй учраас мэргэшсэн сайн ажилтан бэлтгэгдэн гарч байгаа нь эргэлзээтэй байна

## Тосонцэнгэл сум дахь МСҮТ

Тосон цэнгэл сум дахь МСҮТ нь 2016-2021 онд батлагдсан 54-58 орон тоотойгоор, жилд 191-258 суралцагчтай үйл ажиллагаагаа явуулжээ.

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

2016-2021 онд төсвийн төлөвлөгөөгөөр нийт 6.170,1 сая төгрөгийг зарцуулахаас 5.831,0 сая төгрөг буюу 94.5 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж, зардлыг 339,1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

*Хүснэгт № 13. Тосонцэнгэл сум дахь МСҮТ-ийн төсвийн төлөвлөгөө ,гүйцэтгэл*

| Зардлын зүйл анги | 2,016 | | 2017 | | 2018 | | 2019 | | 2020 | | 2021 | | Нийт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 494.4 | 490 | 489.5 | 484.2 | 491.8 | 461.9 | 706.9 | 563.8 | 723.7 | 652 | 709.4 | 709.4 | **3,615.7** | **3,361.3** | **254.40** |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 54.3 | 54.4 | 53.8 | 57 | 51.8 | 54 | 88.6 | 70.7 | 97.7 | 97.7 | 97.7 | 97.7 | **443.9** | **431.5** | **12.40** |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 202.2 | 185 | 240.2 | 232.7 | 181.4 | 193.5 | 261.7 | 205.6 | 198 | 194 | 204.7 | 204.7 | **1,288.2** | **1,216.2** | **72.00** |
| Хангамж, бараа материалын зардал | 13.0 | 19.7 | 13.3 | 20.5 | 8.1 | 8 | 10.1 | 34.9 | 34.9 | 25.7 | 15.5 | 15.5 | **94.9** | **124.3** | **(29.40)** |
| Нормативт зардал | 43.7 | 43.7 | 47.2 | 43.2 | 43 | 42.3 | 43 | 34.4 | 28.1 | 22.6 | 35.9 | 33.1 | **240.9** | **219.3** | **21.60** |
| Эд хогшил худалдан авах | 10.3 | 16 | 3.6 | 12 | 10.5 | 7.2 | 20.3 | 39.8 | 6.3 | 6.3 | 8.5 | 8.5 | **59.5** | **89.8** | **(30.30)** |
| Томилолт, зочны зардал | 4.1 | 4 | 5 | 5 | 5 | 3.5 | 5 | 4.6 | | | | | **19.1** | **17.1** | **2.00** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 0.4 | 1.9 | 2.8 | 2.2 | 3.8 | 3.6 | 3.8 | 3.6 | 33 | 2.8 | 7.1 | 7.1 | **50.9** | **21.2** | **29.70** |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 31.9 | 33.2 | 35.8 | 37.1 | 35.8 | 27.8 | 22.5 | 22.5 | 16.4 | 15.1 | 16.7 | 16.7 | **159.1** | **152.4** | **6.70** |
| Бусад урсгал шилжүүлэг | 5.5 | 5.5 | 11.3 | 11.3 | 50.5 | 50.5 | 55.3 | 55.3 | 40 | 40 | 35.3 | 35.3 | **197.9** | **197.9** | **-** |
| **Нийт төсөв** | **859.8** | **854** | **902.5** | **905.2** | **881.7** | **852.3** | **1217** | **1035.2** | **1178.1** | **1057** | **1131** | **1128** | **6,170.1** | **5,831.0** | **339.10** |

Гүйцэтгэлээр цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал, зардалд, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, норматив зардал,бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх,зардлууд хэмнэгдэж, хангамжийн бараа материалын зардал, эд хогшил худалдан авах зардлууд тус тус хэтэрчээ.

Цалингийн зардлыг 254.4 сая төгрөгөөр хэмнэсэн нь цалинг төлөвлөхдөө 1 багшид олгох танхимын бус цагийг тооцон оруулж төлөвлөөд, харин олгохдоо танхимын бус . цаг буюу үйлдвэрлэлийн дадлагын цагийн цалинг олгоогүйн байна. Энэ нь суралцагчид үйлдвэрлэлийн дадлага орох танхимын бус цагийг аж ахуйн нэгж дээр дадлага хийснээс шалтгаалан хэмнэгддэг байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 72.0 сая төгрөгөөр хэмнэсэн нь хүүхдийн 1 дотуур байр ашиглах боломжгүйн улмаас хааж, халаалтын холболтыг салгасантай холбоотой байна.

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

Аудитаар батлагдсан орон тоог шалгахад  2016-2020 онд цалингийн зардлыг хэт өндөр төлөвлөснөөс хэмнэлт үүсэж, үүний улмаас 4 орон тоо илүү ажиллуулан , 162,5 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан зөрчил илэрлээ.

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын хүрэлцээтэй байгаа эсэхийг хянахад нэг суралцагчид жилд 127,7 мянган төгрөг, 1 сард 15,9 мянган төгрөг ногдож байна.

Мэргэжлийн Боловсролын Сургуулиудын багшлах боловсон хүчний нөөцийг хянахад нийт багш нарын 62,2 хувь нь магистр, 37,8 хувь нь бакалаврын боловсролтой, багшлах эрхтэй, мэргэшүүлэх сургалтуудад цаг тухайд хамрагдсан байгаагаас харахад хангалттай гэж үзэх үндэслэлтэй байна

Мэргэжлийн Боловсролын Сургуулиудыг 2016-2021 онд нийт 2804 суралцагч, мэргэжилтэй ажилтан болон бэлтгэгдэн гарсан байна.

*Зураглал № 1Төгсөгчдийг ажлын байраар хангагдсан байдал*




Мэргэжилтэй ажилтан болон бэлтгэгдэн гарсан нийт суралцагчдын 31 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ ажиллан, 34 хувь нь ажил эрхлээгүй байна.

Тосонцэнгэл сум дахь МСҮТ-ийн үйл ажиллагааг нь шалгахад суралцагчдыг дадлагажуулах дадлагын техникийн бааз хэрэгцээ шаардлагыг хангадаггүй, суралцагчдын анги дүүргэлт хангалтгүй,16 мэргэжлээр тусгай зөвшөөрөл авсан боловч хэрэгцээ шаардлагагүй мэргэжлийн ангид суралцагчийн тоо бага, анги дүүргэлт хангалтгүй байхад багшийг цалинг бүтэн олгодог, 2.5 жилээр анги төгсгөсөн багшид заах цаг байхгүй учир 1-5 сарыг дуустал онцын шаардлагагүй ажил хийж цалин авч байна.

Үүнээс дүгнэлт хийхэд уг сургуулийг ойн аж ахуй, жимс жимсгэнэ боловсруулах, мод модон эдлэл, цэцэрлэгч цэцэрлэгт хүрээлэнгийн ажлын чиглэлээр төрөлжүүлсэн сургууль болгоход анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Учир нь Завхан аймаг дахь ПТК нь суралцагчдын

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

**8.1 Цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг 342 орчим иргэнийг түр ажлын байраар ханган дэмжлэг үзүүлжээ.**

2021 онд хэрэгжсэн нэг онцлог хөтөлбөр бол "Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх" хөтөлбөр юм.

Хөтөлбөрийн зорилго нь Ковид-19 цар тахлын үед үйлдвэрлэл, үйлчилгээ, мал, аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачилга дэмжих, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна.

*Хүснэгт № 14. Хөтөлбөрийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа*

| № | Төсөл, хөтөлбөрийн нэр | 2021 он | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төсөв /сая төгрөг/ | Төсвийн гүйцэтгэл /сая төгрөг/ | Зөрүү /сая төгрөг/ | Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Хамрагдах иргэн | Хамрагдсан иргэн | Эргэн төлөгдөх |
| 1 | 2 | 1 | 2 | 3 | 4 | | 5 | 6 |
| 5 | Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр | 400.9 | 394.7 | 6.2 | 97.6 | 513 | 498 | 260.00 |
| ДҮН | | **400.9** | **394.7** | **6.2** | **80.0** | **513** | **498** | **260.0** |

Тус хөтөлбөрт 550 иргэн хамрагдсан байна.

Нийт зарцуулалтын 260,0 сая 52 иргэнд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгээр 3 жилийн хугацаатай олгож, аж ахуй эрхлэлтийн сургалтад 114 иргэнийг хамруулан 3,4 сая төгрөгийг ажил олгогчийг дэмжих арга хэмжээний урамшуулалд 2 аж ахуйн нэгжид 10,1 сая төгрөгийг, нийтийг хамарсан ажил 325 иргэнийг түр ажлын байраар ханган 90,8 сая төгрөгийг, цагийн ажилд 50 иргэнийг хамруулан 0,3 сая төгрөгийг, зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээнд 6 бүлэгт 30,0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Дээрх хөтөлбөрт хамрагдан ажил эрхэлсэн иргэдийн 80 орчим хувь нь хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг өрхийн гишүүд байна.

**8.2 Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ төсөл хөтөлбөрийн хүрээнд байхгүй байна.**

**8.3 Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтод бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалахаар хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.**

**8.4 Аймгийн хэмжээнд цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, статистик тоо мэдээ гараагүй байна.**

## ДҮГНЭЛТ:

1. Дунд хугацаанд баримтлах бодлогын баримт бичиг нь Засгийн газрын урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдаатай байна.
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөн, явуулсан ч төсвийн төслийн саналаар төлөвлөгөөг баталдаггүй байна.
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдааг холбох аймгийн салбар зөвлөл нь дүрэмд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
4. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үр дүнтэй сайн хэрэгжүүлсэн ч, үр дүнг тооцож ажиллаагүй байна.
5. Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний явц болон гүйцэтгэлд тавих хяналт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна
6. ХЭДС-ийн орлогыг хууль, журмын дагуу бүрэн төвлөрүүлэн журмын дагуу зарцуулсан байна.
7. Хүүхдэд ноогдох хичээл үйлдвэрлэлийн зардлыг бага баталж байгаа нь хөдөлмөрийн зах зээлд мэргэшсэн сайн ажилтан бэлтгэгдэн гарч байгаа нь эргэлзээтэй байна.
8. Тосонцэнгэл сумын МСҮТ-г ойн аж ахуй, жимс жимсгэнэ боловсруулах, мод модон эдлэл, цэцэрлэгч цэцэрлэгт хүрээлэнгийн ажлын чиглэлээр төрөлжүүлсэн сургууль болгоход анхаарч ажиллах нь зүйтэй байна.
9. Аймгийн хэмжээнд цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, статистик тоо мэдээ гараагүй байна.

## ЗӨВЛӨМЖ

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Б.РИНЧИНДОРЖ-д

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Хөдөлмөр эрхлэлтийн дунд хугацааны стратеги /2020-2024/ -ийн бодлогын баримт бичиг нь аймгийн хэтийн хөгжлийг идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц байдлаар боловсруулагдсан тул ХХҮГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хөдөлмөр эрхлэлтийн талаар хэрэгжүүлэх ажлыг тусгахдаа уг бодлогын баримт бичгийг үндэслэн тусгаж байх
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх талаар гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгаж байгаа асуудлаа аймаг орон нутгийн хэрэгжүүлэх бодлоготой уялдуулан боловсруулж байх.
3. Хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн үр дүнд тавих хяналт, зөвлөгөөг тогтмол хийх, хөтөлбөрүүдээс гарсан үр дүнг улирал бүр хэлэлцэн тэмдэглэл хөтлөх
4. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг авсан иргэдийн тандалтын судалгааг хийж, улирал бүр тайланг гаргаж биелэлтийг тооцож байх
5. Санхүүгийн дэмжлэг авсан иргэдээс эцсийн гүйцэтгэлийн тайлан авч, хөтөлбөрийн үр дүнг үнэлж байх

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.ТҮВШИНЖАРГАЛ-д

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Хөдөлмөр эрхлэлтийн дунд хугацааны стратеги /2020-2024/ -ийн бодлогын баримт бичиг нь аймгийн хэтийн хөгжлийг идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц байдлаар боловсруулагдсан тул аймгийн жил бүрийн үндсэн чиглэлд аймгийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийн талаар хэрэгжүүлэх ажлыг тусгахдаа уг бодлогын баримт бичгийг үндэслэн тусгаж байх

2. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийг “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-д заасан эрх, үүргийн дагуу төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах, ХЭДС-ийн орлого зарлагын байдал, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэн, ажлын тайлан боловсруулж байх

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн**

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ӨГӨХ САНАЛ

1. Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулах ажлыг холбогдох газруудад уламжлан шийдвэрлүүлэх
2. Орон нутгийн хөгжлийн бодлогын зорилго, онцлог, өрсөлдөх чадварыг харгалзан үзэж мэргэжлийн боловсролын байгууллагын мэргэжлийн ажилчин бэлтгэхдээ төрөлжүүлэх нь зүйтэй байна.
3. Нэгдсэн бүртгэл мэдээллийн системийн сайжруулалт хийж ,Программаас гарах мэдээллүүдийг уялдаатай болгож, төрийн мэдээлэл цахим сувгуудтай холбох

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА